



ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

2024 оны 10 дугаар сарын 02

Баруун-Урт

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын товч танилцуулга:

Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 469, 487 дугаар тогтоол, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны “Орон тооны хязгаар батлах тухай” А/17 дугаар тушаал, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/15 дугаар тушаалаар 3 хэлтэс, 45 орон тоотойгоор үйл ажиллагаа хэрэгжүүлж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай үр дүнтэй шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангах эрхэм зорилгын хүрээнд ажилтан, албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, биелэлтийг ханган ажиллаж байна..

Нэг. Удирдлага зохион байгуулалт:

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Ө.Бат-Амгалан орон нутгийн сонгуульд нэр дэвшихээр шийдвэрлэсэн тул ХХҮЕГ газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн Б/176 тоот тушаалаар Захиргаа хяналтын хэлтсийн дарга М.Мөнхзулыг газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилон ажиллаж байна.



Зураг 1. Газрын дарга нар ажил хүлээлцсэн.

Ажлын байрны тодорхойлолтын дагуу 28 мэргэжилтэнтэй үр дүнгийн гэрээ, 21 ажилтан, албан хаагчидтай хөдөлмөрийн гэрээ байгуулан хагас, бүтэн жилээр гэрээг дүгнэн ажилласан.

Удирдах дээд байгууллагаас ирүүлсэн албан даалгавар, мэдээ судалгааг тогтоосон цаг хугацаанд нь гаргаж, мэргэжилтнүүдийг холбогдох мэдээллээр ханган, байгууллагын мэдээлэл, санхүүгийн зарцуулалт зэргийг ил тод байдлын



самбар, байгууллагын цахим хаяганд тухай бүр нь тогтмол байршуулан ажилласан.

Хоёр. Хөдөлмөр эрхлэлтийн талаар:

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан e-job программд ажил хайгч 255 иргэнийг бүртгэж, ажилгүйдлийн тэтгэмж авах 43 иргэнийг ажил хайгчаар бүртгэж 191 иргэнийг ажилд зуучлаад байна. Шинээр ажлын байр 333 бий болсоноос эмэгтэй 82 иргэн байна.

“Эм Эм- Цахиурт овоо” ХХК-аас ирсэн ажлын байрны захиалгын дагуу 10 иргэнийг байнгын ажлын байранд 10 иргэнийг түр ажлын байранд зуучлаад байна.



Зураг 2. Ажлын байрны захиалгын дагуу ярилцлага

“Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох” хөтөлбөрийн зар мэдээллийг орон нутгийн BBS телевиз болон байгууллагын цахим хуудсанд байршуулан иргэдэд мэдээллийг хүргэж сургалтад хамрагдах хүсэлтэй 6 иргэнийг бүртгээд байна. Тус хөтөлбөрт нийт 12 мэргэжлээр 32 хүн бүртгүүлээд байна.

Шилдэг “СТАРТ-АП” Залуучуудын гарааны бизнест 10,0 сая төгрөгийн БАТЛАМЖ гардууллаа Шилдэг Старт-Ап залуучуудын гарааны бизнесийн сургалтад 30 залуу хамрагдаж 11 төслөөс шалгарсан 5 төсөл таван долоо хоногийн хурдасгуурт хамрагдаж өөрсдийн бизнес санаагаа хөгжүүлсэн. Хурдасгуур арга хэмжээнд амжилттай оролцсон Баруун-Урт сум Э.Улсболд – “Ирмүүн” хүүхдийн тоглоомын төв, Б.Нямсүрэн “Цондоолой” хүүхдийн сувилахуйн үйлчилгээ, А.Нандинцэцэг “Ертөнц” чөлөөт цагийн клуб, Мөнххаан сум Э.Хүрэлсүх “47 сошиал медиа маркетинг” төслүүд ажлын хэсэгт өөрсийн төслөө танилцуулснаас Мөнххаан сумын Э.Хүрэлсүх “47 сошиал медиа маркетинг” төсөл шалгарч 10,000 сая төгрөгийн буцалтгүй санхүүгийн дэмжлэг авахаар болж “Батламж”-аа гардаж авлаа. Старт-Ап арга хэмжээний талаар орон нутгийн BBS телевиз мэдээлэл бэлтгэн явуулсан.



Зураг 3. Шилдэг Старт- Ап арга хэмжээ

3-р улирлын байдлаар малжуулах арга хэмжээнд хамрагдсан 346 иргэнтэй гэрээ байгуулж малыг нь хүлээлцэж, 346 малчны 2,768,000,000 төгрөгийн санхүүжилтийг шилжүүлсэн



Зураг 4. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхийн малыг газар дээр очиж хүлээлцэн гэрээ байгуулж ажилласан



Жижиг зээлд 14 иргэн төсөл ирүүлсэнийг ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж ХААН, Төрийн банкинд судлуулахаар жагсаалтыг хүргүүлсэн. Төрийн банк 12 иргэнд 10,0 сая, 1 аж ахуйн нэгжид 50,0 сая нийт 155,5 сая төгрөг, ХАА банк 10 иргэнд 10,0 сая, 1 иргэнд 50,0 сая төгрөг нийт 180,0 сая төгрөг аймгийн хэмжээнд 2 аж ахуйн нэгж 22 иргэнд 335,5 сая төгрөг олгоод байна. 17 төслийг ажлын хэсгээр хэлэлцэн

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр ХХҮГ-аас “Монголын удирдлага шинэчлэл менежментийн академи” сургалтын байгууллагатай хамтран “Гоо сайхан, маникюр”-ын сургалтыг зохион байгуулж байна.

Тус мэргэжлийн болон цахим ур чадвар эзэмшүүлэх хосолсон сургалтад ажил, хөдөлмөр эрхлээгүй болон гэртээ бага насны хүүхдээ асран хүмүүжүүлж буй эмэгтэйчүүд, хувиараа хөдөлмөр эрхэлж буй, жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй нийт 18 эмэгтэйчүүд хамрагдаж байна. Уг сургалт нь 2024 оны 08 сарын 05-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаанд үргэлжлэх юм.



"АЖИЛ ОЛГОГЧ, БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ЗӨВЛӨГӨӨН"-ийг Түмэнцогт сумын Засаг даргын Тамгын газар, Нийгмийн даатгалын газартай хамтран зохион байгуулсан.

Зөвлөгөөнд Асгат, Халзан, Сүхбаатар, Түмэнцогт сумын ажил олгогч, бизнес эрхлэгчдийн 60 иргэн хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай



хуулийн талаар мэдээлэл хийж оролцсон сумдын санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 45 иргэний үйлдвэрлэсэн 81 нэр төрлийн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаа зохион байгуулж 13.3 сая төгрөгийн борлуулалт хийж хөтөлбөрт хамрагдсан иргэдэд бүтээгдэхүүнээ борлуулахад дэмжлэг үзүүлсэн.

Үзэсгэлэн худалдаагаар олон нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцсон Асгат сумын иргэн О.Дашзав, Сүхбаатар сумын иргэн Д.Оюунцэцэг, Түмэнцогт сумын иргэн Н.Дэлгэрмаа, Халзан сумын иргэн Т.Баярмагнай нарыг шагнаж урамшуулсан.



Зураг 5. Ажил олгогчдын биенес эрхлэгчдийн зөвлөгөөн

Эргэн төлөлтийн сарын аян зарлаж гэрээний хугацаа дууссан 63 иргэний 50,457.000 мянган төгрөгийг төлүүлсэнээс 12 иргэний 12,169.000 төгрөгийн зээлийг хаалгасан. Сумдаас эргэн төлөлтийн мэдээг өдөр бүр авч байна.

Уулбаян, Сүхбаатар, Асгат, Түмэнцогт, Баруун-Урт сумын 2024 оны 6 сард санхүүгийн дэмжлэг авсан 64 иргэний үйл ажиллагаанд хяналт хийсэн.

Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж байгаа 9 аж ахуйн нэгжээр явж 83 ажлын байрны захиалгыг бүртгэж “Найрсаг Баруун-Урт –театр” өдөрлөгт оролцож хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр иргэдэд мэдээлэл өгч ААН байгууллагаас ирсэн ажлын байрны захиалгыг танилцуулж ажлын байранд иргэдийг бүртгэсэн.



Зураг 7. Салбарын нээлттэй хаалганы өдөр

Мэргэжлийн чадамжийн гэрчилгээг олголоо: Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотын “Мөнх алтан хүлэг” сургалтын байгууллагатай хамтран 27 иргэнд “Талх, нарийн боов, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл” чиглэлээр мэргэжил олгох сургалтыг нэг сарын хугацаанд амжилттай зохион байгууллаа.

Сургалтад хамрагдсан иргэдэд мэргэжлийн чадамжийн гэрчилгээг гардууллаа





Орон нутагт баригдаж байгаа барилга байгууламжаар Хөдөлмөрийн хууль болон ХАБЭА-н хуулийн үзлэг шалгалт хийж зөвлөгөө өгч ажилласан.



Зураг 8. Баруун-Урт суманд үйл ажиллагаа явуулж байгаа барилгад хийсэн хяналт

Талын гал ХХК-тай хамтран хүнд машин механизмын операторын сургалтыг 20 хүнтэй зохион байгуулж Эм эл цахиурт овоо ХХК ирсэн ажлын байрны дагуу 10 иргэнийг ажилд зуучилсан

Гүрээ. Нийгмийн халамжийн нийтлэг үйлчилгээний талаар:

Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлтийг олгов. Нийгмийн халамжийн сангийн улсын төсвийн санхүүжилтийн 2024 оны 08 дугаар сарын мэдээ

№	Төрөл	Хүний тоо	Мөнгөн дүн /мян.төг/
1	Нийгмийн халамжийн тэтгэвэр	1489	4052139,9
2	Нийгмийн халамжийн тэтгэмж	1377	2795514,2
3	Амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж	1302	781954,7
4	Ахмад настны хөнгөлөлт	5994	250808,0
5	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөнгөлөлт	536	122908,9
6	Цалинтай эхийн тэтгэмж	3492	1119430,7
7	Жирэмсэн эхийн тэтгэмж	1087	138088,5
8	Ихэр хүүхэдтэй эхийн тэтгэмж	7	14000,0
9	Өрх толгойлсон олон хүүхэдтэй эх/ эцэг/-д олгох тэтгэмж	146	179800,5
10	Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээ	685	62728,0
11	Алдарт эхийн одонгийн тэтгэмж	5967	759900,0
12	Насны хишиг	3691	537000,0
13	Алдар цолтой ахмадын хөнгөлөлт	9	1487,4
14	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	25277	19735700,0
	Нийт гүйцэтгэлийн дүн	51059	30551460,9



Нийгмийн халамжийн сангийн орон нутгийн санхүүжилтийн 2024 оны 08 дугаар сарын мэдээ

№	Төрөл	Хүний тоо	Мөнгөн дүн /мян.төг/
1	Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ	34	34000,0
2	Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж	15	18000,0
	Нийт дүн	49	52000,0

Ахмад настны тухай хуулийн хэрэгжилт: Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн дагуу 09 дүгээр сард “Олон улсын ахмадын баярын өдөр”-г тохиолдуулан төрийн харъяалалтай 4530 ахмадад 45300.0 мянган төгрөгийн хүндэтгэлийн мөнгийг харилцах дансанд шилжүүлж, ХХҮГ-н даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн цахим мэндчилгээг дэвшүүлсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилт: Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолын дагуу 2023 онд “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс”-н бүрэлдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийн оролцоог хангаж Сүхбаатар сумын 100 хүүхдийн дотуур байрны барилгад ажиллаж хүртээмжийн үнэлгээ хийв.

Чойбалсан хотын 86 жилийн ой, “Алдар гавьяаны өдөр”-ийг тохиолдуулан найрамдал хотуудын хөгжлийн “НӨХӨРЛӨЛ-2024” хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн олон улсын Параспортын тэмцээнд ОХУ-с, Сүхбаатар, Хэнтий, Дорнод, Улаанбаатар хотын 200 гаруй тамирчид спортын 9 төрөлт тэмцээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн С.Балжиннямаар ахлуулсан 9 тамирчин амжилттай оролцлоо. Үүнд:

- Алтан медальд Хараагүй гүйлт С.Эрдэнэ,
- Мөнгөн медальд Хараагүй гүйлт З.Пүрэвжав, Уртын харайлт С.Эрдэнэ, Даам эрэгтэй Э.Хосбаяр, Даам эмэгтэй Д.Батдулам,
- Хүрэл медаль 100 метр гүйлтэд З.Пүрэвжав, 100 метр гүйлт С.Эрдэнэ, Гар барилдаан Д.Батдулам, Дартс С.Балжинням нар медаль авч аймаг орон нутгийн нэрийг гаргалаа.



Зураг. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ



Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний өдрийн үйлчилгээг аймгийн ахмадын хороотой хамтран ажиллах гэрээ байгуулж, Халзан, Сүхбаатар, Уулбаян, Мөнххаан, Баяндэлгэр, Эрдэнэцагаан, Түмэнцогт, Баруун-Урт сумын нийт 140 ахмад настанд үзүүлсэн. Өдрийн үйлчилгээнд эмчийн үзлэг, дасгал хөдөлгөөн, өдрийн хоол, сургалт мэдээлэл, дасгал хөдөлгөөн зэрэг орно.



Зураг. Өдрийн үйлчилгээ үзүүлэв

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний сэргээн засах үйлчилгээг “Чин баясгалангүй” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, Баруун-Урт сумын ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй 120 иргэнд үзүүлсэн. Сэргээн засах үйлчилгээнд эмчийн үзлэг, бариа засал, бумба, дасгал хөдөлгөөн, цахилгаан зүү, хөлний усны массаж, хаш чулуун ор, шарлага гэх мэт үйлчилгээг оруулсан.



Зураг. Сэргээн засах үйлчилгээ үзүүлэв.

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч байгаа 109 өрхийн 13-17 насны 66 хүүхэд байгаагаас 41 нь охид байна. Охидын 5 нь хөгжлийн бэрхшээлтэй, байнгын асаргаатай, өөр аймаг суманд сурч байгаа 4 охид байна. Эдгээр охидын дэлгэрэнгүй судалгааг өрх нэг бүртэй холбогдон гаргаж “Охидын шивнээ” Аймгийн ЭМГ-ын Хүнсний аюулгүй байдал, эрүүл хооллолт, хоол тэжээлийн асуудал хариуцсан мэргэжилтэн Э.Сувд-Эрдэнэ, АЗДТГ-ын Залуучуудын хөгжлийн төв, жендерийн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн А.Магадцэцэг, Баруун-Урт сумын ЗДТГ-ын сэтгэл зүйч Д.Оюун нартай хамтран зохион байгууллаа.

Сургалтанд Сүхбаатар аймгийн Баруун-Уртын сумын 1 дүгээр сургуулиас 10, 2 дугаар сургуулиас 6, 3 дугаар сургуулиас 1, 4 дүгээр сургуулиас 2, “Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төв” сургуулиас 6 нийт 25 хүүхэд оролцлоо.



Зураг. “Охидын шивнээ” арга хэмжээ

Сургалтанд оролцох охидод урилга гардуулж, төлбөртэй сургалт хичээллэдэг багш нартай уулзаж санал болгосны үндсэн дээр Б. Хуланг волейбол, С.Нарансолонгыг “Нарны хүүхдүүд” дуу бүжгийн клубд тус бүр 1 жил, С.Мөнгөндолгионыг үндэсний бичгийн сургалтад 3 сар, Б.Амин-Эрдэнэ, М.Чулуунчимэг нарыг тус бүр 1 сар англи хэлний 100% үнэ төлбөргүй сургалтад хамрагдах эрхийн бичгээр шагналаа.



Зураг. “Охидын шивнээ” арга хэмжээ

Энэхүү сургалтаар охидод тулгамдаж буй асуудлын талаар ярилцаж, өсвөр насны сэтгэлзүйгээ даван туулах, биеэ авч явах соёл, өөрсдийгөө хамгаалах эрх үүрэг, эрүүл ахуйн мэдлэг мэдээллийг өгч, хооронд нь баг болгон бүлгийн ажил хийлгэж үр дүнтэй цагийг өнгөрүүллээ.





Баруун-Урт сумын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлдэг “Өсөхдэлгэр-Ундрах” дэлгүүр нь тус бүр 30000 төгрөгний хичээлийн багц 10 ширхэг, “Баялагийн ундрах” дэлгүүр нойтон сальфетик, саван тус бүр 30 ширхэг нийт 360000 төгрөгний тусламжийг үзүүлсэнээр хүүхэд бүрт гарын бэлэг гардууллаа.



Зураг. “Охидын шивнээ” арга хэмжээ

Зорилтод бүлгийн хүүхдүүдэд хичээлийн хэрэгсэл гардууллаа. Нийгмийн халамжийн дэмжлэг тусалцаа зайлшгүй шаардлагатай Баруун-Урт сумын 4 дүгээр багийн иргэн Н.Д-нь ам бүлдээ 11-үүлээ 9 хүүхэдтэйгээ амьдардаг. Үүнээс сургууль, цэцэрлэгийн насны хүүхэд 7.



Өрхийн 1-р дүгээр ангид элсэн орж байгаа сургуулийн насны хүүхдүүдэд Баруун-Урт сумын 7 дугаар багийн иргэн Г.Баадайн гэр бүл болон Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн Б.Энхнаран нараас 250 гаруй мянган төгрөгийн хичээлийн хэрэгсэл гардууллаа.

Дөрөв. Төсөв санхүүгийн талаар:

Орлого санхүүжилтийн талаар: Улсын төвлөрсөн төсвөөс 277,893.7 мянган төгрөгийн санхүүжилт авах ёстойгоос 276,893.7 мянган төгрөг авч 100 хувь санхүүжигдсэн.

Орон тоо, цалингийн сан: Батлагдаж ирсэн төсвийн хүрээнд 43 хүний орон тоотойгоор ажиллаж цалингийн зардалд 843.6 сая төгрөг батлагдсанаас 810.5 сая төгрөг зарцуулсан.

Үүнд : Үндсэн цалинд 490,637.4 мянган төгрөг

Зэрэг дэвийн нэмэгдэл 27 хүнд 60,115.4 мянган төгрөг

Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл 37 хүнд 48,544.9 мянган төгрөг

Мэргэшлийн зэргийн нэмэгдэл 3 хүнд 9,278.1 мянган төгрөг

Ур чадварын нэмэгдэл 9 хүнд 13,920.5 мянган төгрөг

Унаа хоолны хөнгөлөлт 43 хүнд 77,930.0 мянган төгрөг

Орон нутгийн нэмэгдэл /орон нутгийн төсвөөс/ 43 хүнд 21,451.2 мянган төгрөг

Орон нутгийн нэмэгдэл /улсын төсвөөс/ 43 хүнд 62,344.8 мянган төгрөг



Үр дүнгийн урамшуулал 42 хүнд 21,743.8 мянган төгрөг

Мөн 10 албан хаагчид нэг удаагийн тэтгэмж урамшуулалд 2.5 сая төгрөг, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн тэтгэмж 1 хүний 42,064.0 мянган төгрөг, Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад мөнгөн урамшуулалд 25 хүний 161,232.1 мянган төгрөг тус тус зарцуулсан.

Жирэмсэн, амаржсаны тэтгэмж авсан 3 ажилтан, хөдөлмөрийн чадвар түр алдсан 5 ажилтны тэтгэмжийн тооцооллыг нэг бүрчлэн хийж 1912.9 мянган төгрөгийг нийгмийн даатгалын хэлтсээс нэхэмжлэн авч нийт хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн зардалд 5,420.6 мянган төгрөг олгосон.

Зургаа. Дотоод хяналт шалгалтын талаар:

Хөдөлмөр эрхлэлтийн чилгэлээр: Байгууллагын дотоод хяналтаар 2019 онд Орон нутгийн онцлог хэрэгцээнд нийцүүлсэн зорилтот төсөл арга хэмжээнд хамрагдсан Мөнххаан сумын иргэн Б.Мөнхтэнгэрийг шүүхийн байгууллагад шилжүүлэн, хугацаа хэтэрсэн зээлийн эргэн төлөлт болох 9,700.000 мянган төгрөгийг ХЭДС-ийн 100120037010 дансанд төлүүлж зээлийг хаалгасан.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2024 онд ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт хамрагдсан Баруун-Урт сумын 21 иргэний үйл ажиллагаанд хяналт хийсэн.

Баяндэлгэр сумын сэг зэм устгалд ажилласан 73 иргэний материалд хяналт хийж олгохоор шийдвэрлэсэн.

ХЭДС-аас төсөл хөтөлбөрт хамрагдаж зээлийн эргэн төлөлтийн хугацаа хэтэрсэн 3 иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлсэн.

“Баяжих Олон-од ” ХХК нь Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны ажил олгогчийг дэмжих арга хэмжээний дагуу 6 сараас дээш ажил идэвхтэй хайж байгаа хөдөлмөр эрхлэлтийн E-Job програмд бүртгэлтэй зорилтот бүлгийн иргэн Дорждэрэм овогтой Адъяаг үйлчлэгчийн орон тоонд 2023 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс эхлэн ажиллуулахаар гэрээ байгуулж, ажил олгогч, ажилтны бусад холбогдох

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангаас 2022, 2023 онуудад төсөл хөтөлбөрт хамрагдаж, хуваарийн дагуу төлөөгүй график хугацаа хэтэрсэн, гэрээний хугацаа дууссан иргэдтэй утсаар холбогдож, 1 иргэний 250,0 мянган төгрөгийг төлүүлсэн.

Нийтийг хамарсан ажилд ажилласан материал ирүүлсэн Уулбаян, Сүхбаатар суманд сэг зэм устгах ажилд ажилласан 67 иргэний жагсаалтаас бүртгэлийг тулгаж, иргэдтэй утсаар холбогдож ажилласан талаарх мэдээллийг авлаа. Иргэдтэй байгуулсан гэрээнд гарын үсэг зөрүүтэй, баримт бичгийн хуулбарын хугацаа дууссан, ибаримт үүсгэсэн баримт хавсаргаагүй зэрэг зөрчил илэрч, нэн даруй засуулж, шилжүүлэг хийлгүүлэхээр холбогдох мэргэжилтэнд шилжүүлүүлсэн.



Нийгмийн халамжийн үйлчилгээний чиглэлээр: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асаргаа, хүүхдийн мөнгөний материалыг эцэг, эх хооронд шилжүүлж өгөх тухай нэг иргэний өргөдөл ирсэний дагуу ирүүлсэн материалд хяналт хийж байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дах заалтын дагуу Өдрийн үйлчилгээнд хамрагдсан Түмэнцогт-8, Уулбаян-8, Баяндэлгэр-10 нийт 28 ахмад настны материалыг ehalamj.mn халамжийн нэгдсэн системтэй тулгаж хяналт хийхэд 1 ахмад настан 2024 оны 7 дугаар сард нас барсан боловч уг үйлчилгээнд 2024 оны 6 дугаар сард хамрагдсан байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дэх заалтын дагуу Сэргээн засах үйлчилгээ үзүүлж буй “Чин баясгалангүй” ХХК-ийн үйл ажиллагаанд хяналт хийж үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор газрын даргын 2024.09.17-ны өдрийн 01/305 тоот хугацаатай зөвлөмжийг хүргүүлж ажилласан.

Мөн сэргээн засах үйлчилгээний 1 дүгээр ээлжийн 40 иргэний жагсаалтад хяналт хийхэд 1 иргэний регистр, овог нэр зөрүүтэй шийвэгдсэнийг хариуцсан мэргэжилтэнд хэлж засварлуулсан.

Салбарын хяналтын чиглэлээр:



ТӨРИЙН БОЛОН ТӨРИЙН ОЛЧИТ
БАЙГУУЛЛАГУУЛАД

Хуулийн хэрэгжилт зангих тухай

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийлмийн харицаанд оролцох тэгш эрх, түүний хангах хэрэгжүүлэх хамгаалах талаар төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн гүйцэтгэх эрх, үүргийг хууль тогтоомжид тодорхой заасан байдаг. Үүнийг хэрэгжүүлэх зорилго журманд дараах хуулийн заалтуудыг мөрдөж ажиллахыг зөвлөж байна. Түнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүн ажилд орох, албан тушаал дэвших, шалын нэгд, нөхөн олговор авах, хэвлэлээр зарлах, эдийн засагчид дэмжээс арга хэмжээнд бусадтай адил тэгш хамрагдах эрхтэй. (Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 17.1 дэх заалт)

2. Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүний

Хөдөлмөрийн улсын /ахлах/ байцаагчийн зөвлөмж

Улсын байцаагчаас тээврийн салбарт гарч болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж 15 заалттай зөвлөмжийг ачаа тээврийн компаниудын групп байршуулсан.

Зураг: Сургалт, сурталчилгаа

21 аж ахуйн нэгж байгууллагын 158 ажилтан албан хаагчийг сургалтад хамруулж хөдөлмөр эрхлэлт болон аюулгүй байдлыг хэрхэн ханган ажиллах, анхаарах асуудлаар мэдээллийг хийж сурталчлан ажилласан.



Зураг:Төлөвлөгөөт хяналт, шалгалт



Төлөвлөгөөт 8 аж ахуйн нэгжид хяналт шалгалтыг хийж улсын байцаагчийн 114 заалттай албан шаардлагыг хүргүүлж, хяналт шалгалтаар 2 аж ахуйн нэгж байгууллагад 15549.9 мянган төгрөгийн нөхөн төлбөрийн актыг тогтоож, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг 2 аж ахуйн нэгж байгууллагад явуулж 6000 нэгжийн торгуулийн арга хэмжээг авсан.

Үр дүн: Салбарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багаар цалин хөлс олгосон 10 албан хаагчид 15549.9 мянган төгрөгийг олгуулж нийгмийн баталгааг хангуулсан.



Зураг: Хянан баталгаажуулалт



Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоол “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу 1 аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн ослын актыг om.inspection.gov.mn цахим системд хугцаанд бүртгүүлж баталгаажуулан аж ахуйн нэгж байгууллагад мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгсөн.

Зураг: Төлөвлөгөөт бус хяналт, шалгалт

Иргэнээс ирүүлсэн гомдлын дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гомдолд дурдагдсан асуудлын хүрээнд хяналт шалгалтыг хийлээ. Хяналт шалгалтаар ажилтны ээлжийн амралтын цалинг нөхөн тооцуулан гомдлыг барагдуулсан.

Үр дүн: Иргэний гомдлыг барагдуулж ээлжийн амралтын цалин болох 1041.4 мянган төгрөгийг нөхөн олгуулсан.

Долоо. Мэдээлэл технологийн талаар: Аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/420 дугаар захирамж, Цагдаагийн газрын даргын 225 тоот мэдэгдлийн дагуу гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үр дагаварыг арилгад шаардлагатай теле камерын зардлыг төсөвт суулгаж шийдвэрлүүлж холболтын ажлыг хийж камерийг суурилуулаад байна.

**Найм. Хүний нөөц, сургалтын талаар:**

Тулгар төрийн 2233, Их Монгол улс байгуулагдсаны 818, Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 103 жил, Сүхбаатар аймаг байгуулагдсаны 82 жилийн ойн баяр наадмыг тохиолдуулан хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбартаа олон жил үр бүтээлтэй ажилласан ахмад ажилтан, албан хаагчдыг Төрийн дээд одон медаль болон салбарын, аймаг орон нутгийн шагналаар шагнаж урамшуулсан.

Төрийн дээд АЛТАН ГАДАС одонгоор байгууллагын ахмад ажилтан Г.Цэрмаа, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЛБАРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН"-р ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал хариуцсан мэргэжилтэн С.Балжинням, даргын туслах, архив бичиг хэргийн ажилтан Ш.Ариунцэцэг, ахмад ажилтан Л.Баатар, ахмад ажилтан Б.Эрдэнэцогт, ХӨДӨЛМӨРИЙН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН"-р Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Б.Мөнх-Эрдэнэ, Түвшинширээ сумын хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ч.Алтантуяа, нярав Н.Наранзул, Хөдөлмөрийн нийгмийн хамгааллын яамны "ЖУУХ БИЧИГ"-ээр Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Ц.Алтансүвд, Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч Г.Гэрэлцацрал, Хөдөлмөр эрхлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн Ц.Уугантуяа, Жижүүр М.Батжаргал, үйлчлэгч И.Төмөрчөдөр, Аймгийн Засаг даргын ХҮНДЭТ ЖУУХ БИЧИГ"-ээр Халзан сумын хөдөлмөр эрхлэлт халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхболд, Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ, зорилтот бүлгийн хүн ам, өрхийн хөгжил хариуцсан мэргэжилтэн Б.Мөнх-Оюун нар шагнагдсан.





БАЙГУУЛЛАГЫН ДОТООД ЖУРАМ ШИНЭЧЛЭН БАТАЛЛАА

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулж, ажилтан албан хаагчдынхаа “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр нэмэлт өөрчлөлтийг хамт олны хурлаар хэлэлцэн 100% саналаар баталлаа.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулж, ажилтан албан хаагчдынхаа “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр нэмэлт өөрчлөлтийг хамт олны хурлаар хэлэлцэн 100% саналаар баталлаа.



Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын ажилтан, албан хаагчдын 2024 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн хуралдаанаар хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулж, ажилтан албан хаагчдынхаа “Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх чиглэлээр нэмэлт өөрчлөлтийг хамт олны хурлаар хэлэлцэн 100% саналаар баталлаа.

Зураг: Байгууллагын дотоод журам шинэчлэн баталлаа

Байгууллагын facebook page хуудас, sukhbaatar.hudulmur-halamj.gov.mn цахим хуудас, ил тод байдлын мэдээллийн самбарт нийт 124 мэдээллийг хос бичгээр байршуулж иргэд олон нийтэд сурталчилж байна.

Дүгнэлт:

Захиргаа хяналтын хэлтсийн хамт олон 2023 онд хийж хэрэгжүүлэхээр 30 ажил арга хэмжээ төлөвлөснөөс 3 ажил арга хэмжээг хэрэгжүүлээгүй буюу хэрэгжилт 90% тай байна.

Хэрэгжүүлгүй 3 ажил арга хэмжээ нь:

1. Байгууллагын ХАБЭА-н зөвлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалт зохион байгуулах
2. Төрийн үйлчилгээний албан хаагчдын аюулгүй ажиллагааны зааварчилгаа боловсруулж, батлуулах, эрсдлийн үнэлгээ хийх
3. Сүхбаатар үйлдвэрлэв борлуулалтын цэгийн үйл ажиллагааг сурталчилсан шторк бэлтгэж мэдээллийг хэрэгслээр түгээх гэсэн 3 арга хэмжээ биелээгүй болно.

Албан хаагчдын /төвийн болон сумдын/ ээлжийн амралттай тохиолдолд ажил үүргийг орлон гүйцэтгэх албан хаагчийг тушаалаар томилж төрийн үйлчилгээг шуурхай зохион байгуулах саналтай байна. /Жнь: Сумдын мэргэжилтэн ээлжийн амралттай байхад хэн иргэдийн материалыг хүлээн авах, хэн амьжиргааг дэмжих зөвлөлийг хуралдуулах зэрэг тодорхойгүйгээс иргэд тухайн сард авах мөнгөө дараа сард нөхөн авч байна. /

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг “7:4:10” арга зүйн сургалтад 5 удаа

Удирдлагын академийн төрийн албан хаагчийн мэргэшүүлэх /эрхэлсэн/ багц сургалтад хамрагдаж байна.

Хүүхдийн эрхийн хорооны ментор хөтөлбөрт хэрэгжиж байгаатай холбогдуулан хүүхдийн эрхийн хуульзүйн хорооны сургалтад 1 хүн хамрагдсан.



“Цахимд зөв байя” Кибер аюулгүй байдлын сургалтад 4 хүн хамрагдсан.
Хот байгуулалт барилга орон сууцжуулалтын яамнаас “Орон сууцжуулах форум” арга хэмжээнд 2 хүн оролцсон .

Баруун-Урт сумын засаг даргын тамгын газраас зохион байгуулсан
Сэтгэлзүйч С.Наранбаатарын “Тогтвортой гэр бүлийн харилцаа, тогтвортой ажил амьдралын үндэс” лекцэд байгууллагаараа хамрагдсан.

Төрийн албан хаагчдыг чадавхижуулах, мэргэшүүлэх зорилгоор сургалтанд хамрагдах нөхцөл боломжоор нь бүрэн хангаж ажиллалаа.

ХЯНАСАН:ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ М.МӨНХЗУЛ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: ХҮНИЙ НӨӨЦ , ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ш.АРИУНЦЭЦЭГ